

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага.....	11
3.5.3 Өр төлбөр	11
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
3.7 Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	13
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	14
4. Менежментийн захидал.....	15
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.03.25 № 01/1003

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар тайлант онд 55 зорилтын хүрээнд 112 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 88.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,395,112.8	1,803,038.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,301,130.9	1,716,578.9
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,024,782.8	1,716,578.9
31210	Төгрөг	3,024,782.8	1,716,578.9
31213	Арилжааны банк дахь харилцах	3,024,782.8	1,716,578.9
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	276,348.1	0.0
33	АВЛАГА	93,981.8	86,459.6
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	93,981.8	80,368.9
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.0	6,090.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,395,112.8	1,803,038.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,119,789.4	1,428,886.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,119,789.4	1,428,886.0
41300	Өглөг	2,119,789.4	1,428,886.0
41360	Бусад өглөг	2,119,789.4	1,428,886.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,119,789.4	1,428,886.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,275,323.4	374,152.6
51	Засгийн газрын хувь оролцоо	1,275,323.4	374,152.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,275,323.4	374,152.6
51210	Өмнөх үеийн үр дүн	-3,560,817.6	1,908,443.6
51220	Тайлант үеийн үр дүн	4,836,140.9	-1,534,291.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,395,112.8	1,803,038.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	689,270,820.1	1,609,101,383.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,067,716.3	49,753,442.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,067,716.3	49,753,442.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,067,716.3	49,753,442.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,067,716.3	330,266.1
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.0	49,423,176.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	688,203,103.8	1,559,347,941.4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	688,203,103.8	1,559,347,941.4
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,203,103.8	1,559,347,941.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	684,434,679.2	1,610,635,674.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,434,679.2	1,610,635,674.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,143,548.3	1,470,942.7
2107	Томилолт, зочны зардал	50,818.8	16,797.9
210702	Дотоод албан томилолт	50,818.8	16,797.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	889,179.1	1,431,617.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	460,727.1	1,115,217.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	230,414.8	172,329.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	198,037.1	144,070.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,550.4	22,527.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	203,550.4	22,527.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	683,291,130.9	1,609,164,731.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	664,756,825.1	1,582,272,010.1
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	664,756,825.1	1,582,272,010.1
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,534,305.8	26,892,721.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,931,380.0	25,350,254.8
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	602,925.8	1,542,466.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,836,140.9	-1,534,291.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,836,140.9	-1,534,291.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	689,270,820.1	1,609,101,383.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,067,716.3	49,753,442.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,067,716.3	49,753,442.1
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,067,716.3	49,753,442.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,067,716.3	330,266.1
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.0	49,423,176.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	688,203,103.8	1,559,347,941.4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	688,203,103.8	1,559,347,941.4
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	688,203,103.8	1,559,347,941.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	686,828,366.4	1,610,685,935.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	686,828,366.4	1,610,685,935.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,808,814.5	1,413,172.9
2107	Томилолт, зочны зардал	50,818.8	16,797.9
210702	Дотоод албан томилолт	50,818.8	16,797.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,554,445.2	1,373,847.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,141,068.2	1,057,447.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	215,339.9	172,329.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	198,037.1	144,070.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,550.4	22,527.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	203,550.4	22,527.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	685,019,551.9	1,609,272,762.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	666,485,246.1	1,582,373,950.2
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	666,485,246.1	1,582,373,950.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,534,305.8	26,898,812.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,931,380.0	25,356,345.5
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	602,925.8	1,542,466.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,442,453.7	-1,584,552.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,442,453.7	-1,584,552.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	858,677.2	3,301,130.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,301,130.9	1,716,578.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-2,272,536.0		-2,272,536.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,288,281.5		-1,288,281.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-3,560,817.6		-3,560,817.6
9	Тайлант үеийн үр дүн	4,836,140.9		4,836,140.9
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,275,323.4		1,275,323.4
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,275,323.4		1,275,323.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	633,120.2		633,120.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,908,443.5		1,908,443.5
19	Тайлант үеийн үр дүн	-1,534,291.0		-1,534,291.0
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	374,152.6		374,152.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,643,835,541,400.00	1,534,277,300,157.83	109,558,241,242.17	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,643,835,541,400.00	1,534,277,300,157.83	109,558,241,242.17	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,899,036,900.00	1,413,172,947.25	485,863,952.75	74.4
2107	Томилолт, зочны зардал	41,678,200.00	16,797,910.00	24,880,290.00	40.3
210702	Дотоод албан томилолт	41,678,200.00	16,797,910.00	24,880,290.00	40.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,668,961,700.00	1,373,847,437.25	295,114,262.75	82.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,102,190,000.00	1,057,447,361.85	44,742,638.15	95.9
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	328,726,700.00	172,329,681.00	156,397,019.00	52.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	238,045,000.00	144,070,394.40	93,974,605.60	60.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,397,000.00	22,527,600.00	165,869,400.00	12.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	188,397,000.00	22,527,600.00	165,869,400.00	12.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,641,936,504,500.00	1,532,864,127,210.58	109,072,377,289.42	93.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,641,936,504,500.00	1,532,864,127,210.58	109,072,377,289.42	93.4
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,641,936,504,500.00	1,532,864,127,210.58	109,072,377,289.42	93.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,643,835,541,400.00	1,533,997,686,593.93	109,837,854,806.07	93.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,643,835,541,400.00	1,533,997,686,593.93	109,837,854,806.07	93.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,643,835,541,400.00	1,533,997,686,593.93	109,837,854,806.07	93.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	3,301,130,940.56	-3,301,130,940.56	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,716,578,908.98	-1,716,578,908.98	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөх талаар зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 18-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ, Г.Түвшинзаяа нар гүйцэтгэв.

Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/198 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр
- Нийгмийн халамжийн тэтгэмж
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль болон салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актаар зохицуулагдаж байгаа ба Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд дараах нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Ахмад настны нийгмийн халамжийн үйлчилгээ
- Зорилтот бүлэгт чиглэсэн тэтгэвэр, тэтгэмж
- Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа
- Хүүхдийн мөнгө

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамж
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
- Зорилтот өрхийн хөгжлийг хангах төсөл хөтөлбөр
- Нийгмийн ажлын арга зүй
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа
- Төрөлжсөн асрамж

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийгмийн халамжийн сан нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт, мониторингийн газар нь тайлант онд Төв, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул, Говь-Алтай аймгийн ХХҮГ, Баянзүрх дүүргийн ХХҮХ-ийн нийгмийн халамжийн сангийн 2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Мөн 21 аймаг 9 дүүргийн газар, хэлтсүүдэд нийгмийн халамжийн тэтгэвэр авагч иргэдийн мэдээллийг НДС-аас тэтгэвэр авагч иргэдийн мэдээлэлтэй тулгаж, 82 иргэнд 225.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг Нийгмийн халамжийн сангаас давхардуулж олгосон зөрчлийг илрүүлж, 67.5 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 81.8 сая төгрөгийн зөрчлийг шүүхэд шилжүүлж, 76.4 сая төгрөгийг хуваарь гарган төлүүлэх арга хэмжээг авч ажилласан байна.

Нийгмийн халамжийн сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,610,410.8 сая төгрөгийн 1 хувь буюу 16,104.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 16,106.4 сая төгрөгөөр тогтоосон нь санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнд өөрчлөлт орсонтой холбоотой болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,301.1 сая, эцсийн үлдэгдэл 1,716.6 сая төгрөг болж, 1,584.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	3,024.8	1,716.6	-1,308.2	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	276.3	-	-276.3	
Дүн	3,301.1	1,716.6	-1,584.5	100.0

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ХААН банканд байршиж байгаа 188 дансны 212.7 сая, Төрийн банканд байршиж байгаа 81 харилцах дансны 1,503.8 сая төгрөг байна. Үүнээс 1,428.9 сая төгрөг нь олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн үлдэгдэл, 287.7 сая төгрөг нь оны эцэст арилжааны банкин дахь харилцах дансанд тооцсон хүүгийн орлого болон буцаасан орлогын үлдэгдэл бүртгэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 94.0 сая, эцсийн үлдэгдэл 86.5 сая төгрөг болж, 7.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	94.0	80.4	-13.6
Татаас, санхүүжилтийн авлага		6.1	6.1
Дүн	94.0	86.5	-7.5

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд:

- Орхон аймгийн ХХҮГ болон ХУД, СХД, БГД-ийн ХХҮХ-ийн Капитал банканд байршиж байсан тэтгэвэр, тэтгэмжийн дансны үлдэгдлийг тус банкны үйл ажиллагаа татан буугдсантай холбоотойгоор авлагаар бүртгэсэн 77.1 сая төгрөгийн;
- Архангай, Дархан, Баянзүрх дүүргийн газар, хэлтсийн иргэдэд илүү олгосноос үүссэн 3.2 сая төгрөгийн;
- Орхон, Баян-Өлгий аймгийн ХХҮГ-ын нэр данс зөрүүгээс үүссэн, жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлснээс татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн 6.1 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

3.5.3 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2,119.8 сая, эцсийн үлдэгдэл 1,428.9 сая төгрөг болж, 690.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр	2,119.8	1,428.9	-690.9	100.0
<i>Хувь хүмүүст төлөх өглөг</i>	<i>2,119.8</i>	<i>1,428.9</i>	<i>-690.9</i>	<i>100.0</i>
Нийт дүн	2,119.8	1,428.9	-690.9	100.0

Эх сурвалж: Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд тайлант онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж авах эрх нь үүсэж олголтын файл нь арилжааны банканд илгээгдсэн боловч мөнгөө аваагүй иргэдэд олгох тэтгэвэр тэтгэмжийн 1,428.9 сая төгрөгийн өглөг бүртгэгдсэн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,275.3 сая, эцсийн үлдэгдэл 374.2 сая төгрөг болж, 901.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4. Засгийн газрын хувь оролцоо

				/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Хуримтлагдсан үр дүн	1,275.3	374.2	901.2	100.0
Дүн	1,275.3	374.2	901.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 374.2 сая төгрөг болж 901.2 сая төгрөгөөр буурсан нь 2019 оны олгогдоогүй тэтгэвэр, тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөний үлдэгдлээс иргэдийн аваагүй 646.7 сая төгрөгийн дүнгээр өмнөх үеийн нэмэгдүүлж бүртгэснийг залруулсан болон тайлант үеийн үр дүн 1,534.9 сая төгрөгийн сөрөг үзүүлэлттэй гарсан зэргээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 895,488.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 145,220.4 сая төгрөгөөр бууруулж 750,268.4 сая төгрөгөөр баталсан байна.

2020 оны төсвийн тодотголоор тус сангийн төсвийн нийт зардлыг 1,643,835.5 сая төгрөг болгон анхны баталсан төсвөөс 893,567.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Энэ нь УИХ-аас баталсан коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд цар тахлын үед хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор 0-18 насны хүүхдэд сар бүр 100.0 мянган төгрөг олгохоор, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай бага орлоготой өрхийн насанд хүрсэн хүн бүрд олгодог хүнсний талоньг 32.0 мянган төгрөг, нийгмийн халамжийн сангаас олгодог тэтгэвэр, тэтгэмжийг хүн бүрд 100.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлэх шийдвэр гарсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,643,835.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,899.0 сая төгрөгийг урсгал зардалд, 1,641,936.5 сая төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд зарцуулахаар батлагдаж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,559,347.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож батлагдсан төсвөөс 84,487.6 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,534,283.4 сая төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой байна.

Нэмэлтээр Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нэмэлт санхүүжилтийн төслөөс 2,935.7 сая, гадаад эх үүсвэрээс олгосон тусламжийн орлогоос 46,487.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх болон хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардалд зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Багануур дүүргийн ХХҮХ нь амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллаас 1.2 сая төгрөгийн НДШ-ийг суутган тооцоогүй,
- Хувийн хэргийн болон бусад анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт чөлөөлөлтийн зардал олгосон; / Налайх дүүргийн ХХҮХ 13.0 сая, Баянгол дүүргийн ХХҮХ 31.1 сая, Сүхбаатар дүүргийн ХХҮХ 4.2 сая төгрөг /
- Тэтгэвэр, тэтгэмжийг давхардуулан болон илүү олгосон нь дотоод хяналт шалгалтаар тогтоогдсон зөрчлийг барагдуулаагүй, үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй; /Говь-Алтай аймгийн ХХҮГ 5.3 сая, Налайх дүүргийн ХХҮХ 10.2, Сонгинохайрхан дүүргийн ХХҮХ 27.2 сая, Хан-Уул дүүргийн ХХҮХ 4.1 сая төгрөг /
- Дархан-Уул аймгийн ХХҮХ 0.8 сая төгрөгийн авлага, 1.2 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 133 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийн хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 1,145.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 28.3 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
							Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,145.1	1	1,145.1	-	-	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-	-	
Зөвлөмж	3	28.3	3	28.3	-	-	100.0
Нийт	4	1,173.4	4	1,173.4	-	-	100.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төв сан болон харьяа аймаг, дүүрэг дэх 30 ХХҮГ болон хэлтсийн нийт 31 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 27 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, төв сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 3 байгууллагад МУЕА-ын тушаалаар итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын 27 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 2,817.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,143.2 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 24.5 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 193.8 сая төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 456.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 6.1 сая төгрөгөөр авлагыг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнгийн дахин илэрхийлсэн үлдэгдлийг 633.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд урьд оны олгогдоогүй тэтгэвэр, тэтгэмжийн 1,473.1 сая төгрөгийн зардлыг холбогдох тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн дансанд хуваарилж бүртгээгүй;

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. "Улсын хэмжээнд ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо нь тендерийг шалгаруулахдаа холбогдох хууль тогтоомж болон тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу үнэлгээг хийгээгүйгээс шаардсан баримт материалуудыг бүрэн ирүүлээгүй шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Үүнд: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 13, өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй 1, хүний нөөцийн шаардлагыг хангаагүй 5 зэрэг нийт 19 оролцогч байна. Тайлант онд тус дээрх оролцогч нарт амралт, сувиллын үйлчилгээний төлбөрт 768.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна", 46.1.1-д "энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах", 46.1.2-т "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах", 47 дугаар зүйлийн 47.2-т "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна", 47.2.1-д "техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 525.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 30.9 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 24.5 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 193.8 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 276.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 30 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ХХҮЕГ-ын санхүүгийн тайланд анхаарал татахуйц дараагийн аудитаар авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

- Үйл ажиллагаа нь татан буугдсан Капитал банкнаас авах 77.1 сая төгрөгийн авлага өнөөг хүртэл төлөгдөөгүй;
- ХХҮЕГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нэмэлт санхүүжилтийн төслөөс 25,027.9 сая, Боловсролын чанарын шинэчлэл төслөөс 14,240.0 сая, БСУШС-ын Тусгай зориулалтын шилжүүлгийн зардлын хэмнэлтээс 34,922.0 сая нийт 74,189.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдож хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлыг санхүүжүүлсэн байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал.

3.1.1 Илрүүлэлт:

Тус сангийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2 төсөл арга хэмжээний тендерийн үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулах болон тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" заасныг мөрдөж ажиллаагүй ба захиалагчийн зүгээс хяналт тавьж ажиллаагүй байна.

Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хүүхдийн асрамжийн үйлчилгээ үзүүлэх (277.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй) төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулахдаа тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлагыг тодорхойлсон тендерийн баримт бичигт стандарт, норм, норматив, дүрэм зааварт үндэслэсэн техникийн тодорхойлолтыг боловсруулж бэлтгээгүй, тендерийн үнэлэхдээ тендерийн баримт бичигт шаардсан шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа, татварын тодорхойлолт зэрэг материалуудыг ирүүлээгүй буюу шаардлагад нийцээгүй оролцогчийг шалгаруулсан;
2. Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн гарын авлага, хуулийн эмхэтгэл, тараах материал хэвлэн нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх (180.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй) төсөл арга хэмжээний тендерийн урилгыг 2020 оны 05-р сарын 29-ны өдөр tender.gov.mn-д нийтэлсэн ба тендерийн баримт бичгийн 18.4.2-т "Татвар, НДШ-ийн өр төлбөргүй тухай тодорхойлолтыг 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар гэж тусгасан нь тендерт оролцогч нарыг шаардлага хангасан тендерийн материал ирүүлэх хугацаагаар бүрэн хангаагүй нь өрсөлдөх тэгш эрхтэй байх зарчмыг алдагдуулсан, мөн тендер шалгаруулалтыг хийхдээ оролцогчийн ирүүлсэн санхүүгийн тайлангаар түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх шаардлагыг бүрэн хангаж буй оролцогчийг хангаагүй талаар мэдэгдэлд үндэслэсэн, оролцогч нарын татварын өртэй эсэхийг эрх бүхий байгууллагын албан ёсны тодорхойлолт ирээгүй байх хугацаанд албан бус эх сурвалжид үндэслэн татварын өртэй, өргүйг тодорхойлсон зэрэг нь хуульд заасан хариуцлагатай байх зарчмыг мөрдөж ажиллаагүй байна.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 24 дүгээр зүйлийн 24.1-д "захиалагч тендерт оролцогчдод тендерт бэлтгэж ирүүлэх хангалттай ижил хугацаа олгоно", 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна", 46.1.1-д энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах", 46.1.2-т "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах", 47 дугаар зүйлийн 47.2-т "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна", 47.2.1-д "техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

САГ-2021/7/СТА-ЗГТС

Худалдан авах ажиллагаанд илт тод, хариуцлагатай байх зарчим алдагдах,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Тендерийн баримт бичгийг зохих хууль журмын дагуу боловсруулах, тендерийн үнэлгээг хийхдээ боловсруулсан тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлт болон холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/7/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Нийгмийн халамжийн сан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг -аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
Нийгмийн халамжийн төв сан					
1	Улсын хэмжээнд ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо нь тендерийг шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14-16 дугаар зүйл болон тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу үнэлгээг хийгээгүйгээс холбогдох баримт материалуудыг бүрэн ирүүлээгүй болон шаардлага хангаагүй 19 оролцогчдийг сонгон шалгаруулж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Үүнд: Татвар, нийгмийн даатгалын өртэй 13 оролцогч, өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй 1, ' Багц 1 дээр сувиллын бүтэц, үйл ажиллагаанд тавих стандартад заасан хүний нөөцийн шаардлагыг хангаж, ажиллагсдын 80-с доошгүй хувь нь үндсэн ажилтан байна гэсэн шаардлага хангаагүй 5 оролцогч зэрэг, шаардлагад нийцээгүй материал ирүүлсэн 19 оролцогч байгаа бөгөөд дээрх байгууллагуудын ахмад настанд үзүүлсэн амралт, сувиллын үйлчилгээний төлбөрт 768.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	-	Албан шаардлага	ХХҮЕГ-ын Хяналт, мониторингийн газрын мэргэжилтэн /Үнэлгээний хорооны дарга, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн / үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /	Я.Болд, Б.Дэлгэрдалай
2	Тус сангийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2 төсөл арга хэмжээний тендерийн үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулах болон тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" заасан зарчмыг мөрдөж ажиллаагүй байна	180.0	Зөвлөмж	Эрх зүй хамтын ажиллагааны газрын дарга, НХБХГ-ын мэргэжилтэн, Халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, НХБХГ-ын мэргэжилтэн	Г.Мөнхнасан, Д.Буянжаргал, ^ А.Чимэгсүрэн, Г.Энх-Очир
Багануур дүүрэг ХХҮХ					
3	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллаас ЭМНДШ-ийг суутган тооцоогүй байна.	1.2	Төлбөрийн акт	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	С.Ичинхорлоо Т.Туяацэцэг
4	Байгууллагын санхүүгийн баримтыг Архивын хуулийн дагуу архивлаагүй байна.	-	Зөвлөмж		
Багахангай дүүрэг					
5	Тайлант хугацаанд оруулбал зохих 136.0 сая төгрөгийн 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хоцруулан байршуулсан байна.	-	Зөвлөмж	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Д.Энхтайван Г.Буянхишиг
Баянгол дүүрэг ХХҮХ					
6	Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 222 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Г.Батбаяр Б.Мягмарсүрэн

Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

7	Нийгмийн халамжийн хуулиудын дагуу иргэдэд үйлчилдэг (Протез, ортопед болон тусгай хэрэгслийн худалдаа эрхэлдэг байгууллага, амралт, сувиллын хөнгөлөлттэй үйлчилгээ явуулж буй байгууллага) аж ахуйн нэгж, байгууллагуудын зарим төлбөрийн нэхэмжлэхийн дүн Халамжийн сангийн төлбөрийн хүсэлтээр шилжүүлж буй үнийн дүнгээс зөрүүтэй, зарим үйлчилгээ үзүүлж буй байгууллагын анхан шатны баримт засвартай, зөрүүтэй байна.	12.1	Зөвлөмж		
8	Халамжийн сангаас олгогддог тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг, хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн хуулийн дагуу бүрдүүлэх баримт бичиг дутуу байна.	19.0	Зөвлөмж		
Баянзүрх дүүрэг ХХҮХ					
9	Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн тушаал шийдвэрийг оруулаагүйгээс 25.2 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Л.Цолмонгэрэл В.Лхагвадулам
Баян-Өлгий аймаг ХХҮГ					
10	Шилэн дансны мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Б.Сьезхан Ж.Отгонцэцэг
Говь-Алтай аймаг ХХҮГ					
11	Нийгмийн халамжийн сангаас Нийгмийн даатгалын сантай давхардуулан ХБИ болон АН-ны тэтгэвэр олгосон иргэдээс буцаан төлүүлээгүй байна	5.3	Төлбөрийн акт	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	М.Мянганбуу Ц.Эрдэнэцэцэг
Дархан-Уул аймаг ХХҮГ					
12	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан 7,8 сарын 5 мэдээллийг 8,9 дүгээр сард мэдээлсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	С.Энхболд Э.Буянхишиг
13	Тайлант онд 0.8 сая төгрөгийн авлага, 1.3 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна	2.1	Зөвлөмж өгөх		
14	Тус байгууллага нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн НББ-ийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, журам заавар стандартад нийцүүлэн шинэчлэлт сайжруулалтыг хийж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	-	Албан шаардлага		
Дорнод аймаг ХХҮГ					
15	Шилэн дансны нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 96 мэдээлэл хугацаа хоцроож мэдээллэсэн байна.	183.2	Албан шаардлага	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Н.Мөнхгэрэл Б.Алтанцэцэг
16	Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабараас хоцроож 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн байна.	-	Албан шаардлага		
17	Тайлант онд халамжийн тэтгэмжээ аваагүй иргэдийн өглөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.	8.5	Зөвлөмж өгөх		
Завхан аймаг ХХҮГ					
18	Шилэн дансны мэдээлэлд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээшхи орлого, зарлага, худалдан авалт, тендер сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг мэдээлээгүй, зарим төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	М.Гүрсэд Ө.Нямдэмбэрэл
Налайх дүүрэг ХХҮХ					
19	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ, ортопед, протезийн тусгай хэрэгслийн үйлчилгээ хөтөлбөрөөс анхан шатны баримтгүй зарлага гаргасан.	13.0	Төлбөрийн акт	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Т.Эрдэнэчимэг Х.Лхагвасүрэн
20	Хэлтсийн дотоод хяналтаар тогтоосон 10.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг авлагаар бүртгэж баталгаажуулаагүй, хариуцагч этгээдээр төлүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулаагүй, 10.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	10.2	Албан шаардлага		

Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	Шилэн дансны хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих нийт 262 мэдээлэл байршуулахаас 17 мэдээлэл хугацаа хоцроож, 118 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага		
22	Халамжийн үйлчилгээнд нийт 292.3 сая төгрөгийн худалдан авалт хийснээс 183.9 сая төгрөгийн худалдан авалт Ибаримт цахим системд шивээгүй байна.	183.9	Зөвлөмж өгөх		
Орхон аймаг ХХҮГ					
23	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллыг батлагдсан төсвөөс хэтрүүлж зарцуулсан байна.	0.4	Албан шаардлага	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Х.Эрдэнэбат Б.Батбаатар
24	Халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний дагуу аймгийн Улаанзагалмайн хорооноос зохион байгуулсан зорилтот сургалтанд оролцогчдод олгогдоогүй унааны зардлын 0.4 сая төгрөгийг нэг суралцагчийн сургалтын зардлын дээд хэмжээг хэтрүүлэн бичиг хэргийн болон цайны зардалд нэмж илүү олгосон байна.	0.4	Төлбөрийн акт		
25	Халамжийн үйлчилгээ үзүүлэх олголтын жагсаалтаас үйлчилгээг банк руу илгээсний дараа цуцлахдаа хэрхэн ямар шалтгаанаар цуцалснаа тайлбарлаагүй байна. Мөн халамжийн мөнгөний олголтыг банкнууд дээрх тухайлсан халамжийн сангийн данснаас шууд зарлага гаргаж олгож байгаа нь халамжийн мөнгө зорилтот иргэндээ хүрэхгүй байх эрсдэлийг нэмэгдүүлэхээс гадна халамжийн мөнгө бүгд иргэдийн дансанд шууд ордоггүйтэй холбоотойгоор өөрийн биеэр банк орж амжаагүй иргэдийн халамжийн мөнгийг олголтын жагсаалтаас банк руу илгээсний дараа цуцлаад, дахин өргөдөл гаргуулж / чирэгдэл учрах / дараа жилийн төсвөөс нөхөж олгож байна	8.8	Зөвлөмж өгөх		
26	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 талбарын мэдээллээс 5 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Зөвлөмж		
Өмнөговь аймаг ХХҮГ					
27	Шилэн дансны цахим сайтад байршуулсан мэдээллийг нэг бүрчлэн тулгаж шалгахад 2020 оны 5 дугаар сард 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Ц.Пүрэвсүрэн М.Эрдэнэчулуун
Сонгинохайрхан дүүрэг ХХҮХ					
28	Капитал банкин дахь "Насны хишиг" дансанд байршиж байсан 10.1 сая төгрөгийн авлага барагдуулах өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	10.1	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул Э.Бямбасүрэн
29	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Халамжийн сангийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан журам, илүү олгосон тэтгэмж, тусламжийн мөнгийг бүртгэлд хэрхэн тусгах талаар дансны бичилтийг заагаагүй байна.	-	Зөвлөмж өгөх		
30	Тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 422 мэдээлэл байршуулахаас 330 мэдээллийг хугацаанд нь 63 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 29 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх		
31	Захиргаа хяналтын албанаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн тэтгэмжийг олгохдоо нас барсан иргэний мэдээллийг WAIS програмд тухай бүр шалгаж, тулгалтыг хийхгүй байснаас улсаас олгодог тэтгэмжүүдийг давхардуулан олгосон зөрчлийг бүрэн арилгаагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тэтгэмжийг авлагаар тайлагнаагүй байна.	27.2	Зөвлөмж өгөх		
Сүхбаатар дүүрэг ХХҮХ					

Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

32	2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/17 дугаартай албан тоотоор ирүүлсэн 2020 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн тодруулга, санхүүгийн тайланд харуулсан дүнгүүдийн талаар шинжилгээ, хүүрнэсэн тодорхойлолт, тайлбар, тэмдэглэл, бэлтгээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	М.Отгонтуяа Б.Баяржаргал
33	Алдарт эхийн одонгийн дэвтэр болон иргэний үнэмлэхийн хуулбар нотариатаар баталгаажуулаагүй, бичиг баримтыг хуульд заасны дагуу бүрдүүлээгүй 24 иргэнд 2.7 сая төгрөгийг олгосон байна	2.7	Зөвлөмж өгөх		
34	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 42 мэдээллийг хугацаа хоцроосон, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх		
35	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхдээ төслийн танилцуулга, төлөвлөгөө, тооцоо, судалгаа, бизнесийн үйл ажиллагааны талаарх баримт материалгүй гар урлалын бүлэгт 1.5 сая төгрөгийг олгосон байна.	1.5	Зөвлөмж өгөх		
Сэлэнгэ аймаг ХХҮГ					
36	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 5 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Л.Зоригтбаатар Г.Дорждэрэм
Төв аймаг ХХҮГ					
37	Шилэн дансны төсөв ба гүйцэтгэлд хугацаа хоцроосон 4, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан бичээгүй, 12 дугаар сарын мэдээг мэдээлээгүй, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл, санхүүтэй холбоотой тушаал шийдвэр байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Д.Батцэцэг Д.Саранбаатар
Увс аймаг ХХҮГ					
38	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 5.0 сая төгрөгийн 96 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Д.Цогт-Очир Б.Нямдорж
Хан-Уул дүүрэг ХХҮХ					
39	Нийгмийн халамжийн 11 төрлийн үйлчилгээний хувийн хэрэг болон бэлэн олголтын материалаас түүврийн аргаар 328 иргэний олголтын материалын бүрдэлтэй танилцахад баримт бичгийн бүрдэл дутуу зөрчил илэрсэн.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Б.Бадамсүрэн Г.Уранчимэг
40	Шилэн дансны сайтад хөтлөх ёстой мэдээ тайлангаа бүрэн оруулсан эсэхийг нягтлан бодох бүртгэлийн журналын гүйлгээнээс хөөн шалгахад мэдээг үнэн зөв, бүрэн оруулсан боловч 15 мэдээг хугацаа хоцроон оруулсан байна.	-	Зөвлөмж өгөх		
41	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох хүрээнд Ш324121513 регистрийн дугаартай Эрэнцэн овогтой Лувсанбалдан ахмад настанд Ахмад дайчин ахмад настанд үзүүлсэн мөнгөн тусламж /6101/, Гавьяат цолтон ахмад настанд үзүүлсэн мөнгөн тусламж /6110/ зэрэг цолны мөнгөн тусламжийг давхардуулан олгосноос 2018-2019 онд 3.6 сая төгрөг, 2020 онд 0.5 сая төгрөг нийтдээ 4.1 төгрөгийн цолны мөнгийг илүү олгосон.	4.1	Албан шаардлага		
Ховд аймаг ХХҮГ					
42	Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолд заасны дагуу үйлчилгээ авч буй иргэдийг сумаас аймагт ирж оношоо баталгаажуулж тодорхойлолт гаргуулахыг шаарддагаас улбаатай иргэдийг чирэгдүүлэх, тухайн иргэн зардал мөнгөөр хохирох нөхцөл үүсдэг, нөгөө талаас оношны баталгаажуулалтгүйгээс сангийн хөрөнгийн үр өгөөж буурахаар байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Л.Билэгдэмбэр эл Н.Ариунтуяа

43	Асаргааны тэтгэмж олгохдоо зарим иргэдийн аймгийн ЭХМКомиссын акт болон сумын эрхлэгч их эмчийн тодорхойлолтын хугацаа баримтлаагүйгээс тэтгэмж дутуу олгогдсон.	0.6	Төлбөрийн акт		
Хөвсгөл аймаг ХХҮГ					
44	Ахмад настан болон ХБИ-ний авч байгаа тусгай хэрэгсэл нь тухайн иргэндээ хэрэгцээ шаардлагатай эсэх, Засгийн газрын 2017 оны 316 дугаар тогтоолоор баталсан " Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ"-ийг мөрдөж тусгай хэрэгслийн үнийг олгож байгаа боловч чанар, хийцэд нь хяналт хийхгүйгээр тухайн хэрэгслийг нийлүүлэгч аж ахуйн нэгжээс нь шууд түгээлт хийж байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн	Б.Эрдэнэхуяг Б.Батболд
45	Хүнс тэжээлийн хөнгөлөлт олгох үйл ажиллагаанд журам заавар зөрчигдөж байгаа мөн шаардлага хангаагүй өрхөд хүнс тэжээлийн хөнгөлөлт олгож байна гэсэн нийгмийн зүгээс гарч байгаа санал гомдолд тулгуурлан завсрын аудитаар зөвлөмж хүргүүлж тус байгууллагын дотоод хяналт хийлгэхэд нийт хяналтад орсон 2675 өрхөөс 544 өрх зөрчилтэй байгаа нь илэрч хасагдсан байна. Цаашид ч ийм эрсдэл байх магадлалтай байна.		Зөвлөмж өгөх		
Нийт дүн		674.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 452/АД170065

Улаанбаатар хот

САГ - 2021/7/СТА - БТТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийгмийн халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын хэмжээнд ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо нь тендерийг шалгаруулахдаа холбогдох хууль тогтоомж болон тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу үнэлгээг хийгээгүйгээс шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Үүнд: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 13, өмнөх онд үйл ажиллагаа явуулаагүй 1, хүний нөөцийн шаардлагыг хангаагүй 5 зэрэг, нийт 19 оролцогч байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна", 46.1.1-д "энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах", 46.1.2-т "үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах", 47 дугаар зүйлийн 47.2-т "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна", 47.2.1-д "техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх", 52 дугаар зүйлийн 52.1.5-д "захиалагч худалдан авах ажиллагаанд зохих журмыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийх" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТБОНӨХБАҮХАТухай хуулийг хэрэгжүүлж, Тендерийн үнэлгээг боловсруулсан тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг шаардлагын дагуу үнэлж, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл, Хяналт, мониторингийн газрын мэргэжилтэн Я.Болд, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн Б.Дэлгэрдалай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
С.БАТ-ЭРДЭНЭ
Г.ТҮВШИНЗАЯА

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for consistent letter formation. There is no text or other markings on the page.